



**УВС
ХҮНС**

Эрүүл хүнс
аз жаргалын
эхлэл

Хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлан

2023

АГУУЛГА

1 Компанийн
танилцуулга

3-5 хуудас

2 Бизнесийн үйл
ажиллагаа

6-10 хуудас

3 ҮЗЭСГЭЛЭН ТАНИЛЦУУЛГА

11-12 хуудас

4 Компанийн
хүний нөөц

13-15 хуудас

5 Санхүүгийн
тайлан

16-18 хуудас

Компанийн товч танилцуулга

1942

Улсын үйлдвэрийн газар болон байгуулагдаж хүн амыг хүнсээр хангах үйлдвэрлэл явуулж эхэлсэн.

1998

УВС ХҮНС ХК болон зохион байгуулагдаж хүнсний өргөн нэр төрлийн бараа үйлдвэрлэдэг орчин үеийн компани болон хөгжиж байна.

2006

Дотоод хяналтын лабораторын үйл ажиллагаанд MNS ISO/IEC 17025:2005 стандарт нэвтрүүлж итгэмжлэгдсэн лабораторитой болсон.

2009

Чанарын удирдлагын нэгдсэн тогтолцоо ISO 9001:2008 стандартыг үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд нэвтрүүлсэн.

2020

Чанарын удирдлагын нэгдсэн тогтолцоо ISO 9001:2015 стандарт, хүнсний аюулгүй байдлын удирдлагын нэгдсэн тогтолцоо ISO 22000:2018 стандартыг үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд нэвтрүүлж, баталгаажуулав.

Чацарганы аж ахуйд хөдөө аж ахуйн зохистой дадал GLOBAL GAP газар тариалангийн стандартыг нэвтрүүлж, баталгаажуулав.

2021

Чанарын удирдлагын нэгдсэн тогтолцооны ISO 9001:2015 стандарт хяналтын аудит, хүнсний аюулгүй байдлын удирдлагын нэгдсэн тогтолцооны ISO 22000:2018 стандартын магадлан аудит хийгдсэн. Дотоод хяналтын лабораторийн үйл ажиллагаанд MNS ISO/IEC 17025:2018 стандартын хяналтын аудит хийгдэж, итгэмжлэгдсэн.

2023

Дотоод хяналтын лабораторын үйл ажиллагаанд MNS ISO/IEC 17025:2018 стандартын магадлан аудит хийгдэв.

Компанийн стратеги



Алсын хараа:

Дэлхийд хүндлэгдсэн Made in Mongolia -г бид бүтээнэ.



Эрхэм зорилго:

Экологийн цэвэр нөөцийг дэвшилтэт технологиор боловсруулан эрүүл хүнсийг бүтээж хэрэглэгчдэд хүргэнэ.



Үнэт зүйлс:

Экологийн цэвэр орчин, Хүний нөөц, Өөрсдийн бүтээсэн технологи, Хэрэглэгч



Баримтлах зарчим:

Шудрага байдал, Ёс зүй, Хүндлэл, Зөв хандлага, Хариуцлага, Хөгжүүлэгч

Чанарын бодлого



Бид Чанарын Удирдлагын тогтолцооны стандартуудыг тасралтгүйгээр сайжруулж, хүний нөөцийн хөгжлийг нэн тэргүүнд тавин, хэрэглэгчийн шаардлагыг давуулан биелүүлэх боломжийг ямагт эрэлхийлж, ногоон хөгжилд тулгуурласан үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулах бодлогыг баримтлан ажиллана.

Чанарын бодлогын хэрэгжилтийг хангахын тулд дараах Чанарын зорилтуудыг дэвшүүлэн ажиллана. Үүнд:



1. Байгууллагын ажилтан нэг бүрийн авьяас чадвар, мэдлэг туршлага, нөөц боломж бүрийг нээн илрүүлэхийн тулд сургалт, судалгаа, хамтын ажиллагаанд тулгуурлан хүний нөөцийн хөгжлийг тасралтгүйгээр сайжруулах

2. Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн үйл ажиллагааг тогтмол сайжруулах

3. Ногоон хөгжлийн бодлогод чиглэж үйл ажиллагаандаа эрчим хүч, усны зарцуулалтын хэрэглээг бууруулж, хог хаягдалыг ангилан ялгаж дараагийн дамжлагад шилжүүлэх, ямагт хэмнэлттэй эмх цэгцтэй үйлдвэрлэлийг бий болгоно.



Бизнесийн үйл ажиллагаа



**Газар
тариалан**

**Хүнс
үйлдвэрлэл**



Хүнс үйлдвэрлэл



Чацарганы чанамал, чацарганатай үхрийн нүдний чанамалын шошго шинэчлэгдсэн.



Хүнс үйлдвэрлэл



Өдөрт 2 тн сүү боловсруулж 8 нэр төрлийн сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.

ААРУУЛ

ТАРАГ

БЯСЛАГ

ААРЦ

**ШАР
ТОС**

**ШАР
СҮҮ**

ЦӨЦГИЙ

БАГЦ

Хүнс үйлдвэрлэл



Том сэндвич талх,
Өндөгний болон туна салаттай сэндвич
BBQ, Hawai, Meat Lovers төрлийн пицца
шинээр гаргалаа.



**сэндвич
талх**



**Meat lovers
PIZZA**



**BBQ
PIZZA**

Газар тариалангийн үйл ажиллагаа



5 га талбайд тариалалт хийв.



**20,000 ширхэг суулгац
бойжуулгын талбайд
шилжүүлэн суулгав.**

Үзэсгэлэн танилцуулга



Амар байна уу? үзэсгэлэн худалдаанд оролцлоо.

Эх оронч худалдан авалт, үндэсний үйлдвэрлэл 2023 арга хэмжээнд оролцлоо.



“Дэлхийн Экспорт Хөгжлийн Форум”, Олон Улсын жижиг, дунд үйлдвэрийн өдөр-2023” үйл ажиллагаанд зориулсан олон улсын үзэсгэлэн худалдаанд оролцлоо.



Үзэсгэлэн танилцуулга



Цагаан сар 2023 үзэсгэлэн худалдаанд гурилан бүтээгдэхүүн төрөлд шалгарлаа.



Япон улсын Осака хотын Шига мужийн “Монголын өдөрлөг”-ийг зохион байгуулахад хамтран ажиллаа.


2023.01.19-нд чацарганы болон сар шинийн бүтээгдэхүүний амталгаат худалдаа зохион байгуулав.



Нээлттэй Увс аймаг үзэсгэлэн худалдаанд оролцов.



Хүний нөөц



SMART HCM БОЛОН SMART TIME ATTENDANCE
систем нэвтэрч компанийн хүний нөөцийн
мэдээлэл, цаг бүртгэл цахим боллоо

Хүний нөөцийн бодлого

Компанийн ажилтан бүрийн мэдлэг, чадварыг судлан, ажлын туршлага, нөөц чадавх боломжийг нээн илрүүлж хөгжүүлэн, сургалтад тасралтгүй хамруулан, багаар ажиллах чадварт сурган хөдөлмөрийн бүтээмжтэй хамт олон бүрдүүлэхэд бодлогын зорилго оршино.

Компанийн эрхэм зорилгод нийцүүлэн ажилтанд чиглэсэн үйл ажиллагааг хүний нөөц боломжоо ашиглан явуулснаар өрсөлдөх чадвар бүхий ажиллах хүчийг бүрдүүлж, төлөвшүүлэх бодлого баримталдаг.

Үүнд:

- Бид компанийн үнэт зүйлс болон ёс зүйн зан төлөвийг зохистойгоор баримтлан ажиллахыг ажилчиддаа төлөвшүүлэхийг хичээдэг.
- Байгууллагын дотоод журам, хөдөлмөрийн гэрээг нийт ажилтнууддаа нээлттэй танилцуулж, хөдөлмөрийн харилцааны холбогдох хуулиудыг чанд баримталж ажилладаг
- Мэргэжлээрээ өсөж хөгжих боломжийг олгож, чадварлаг боловсон хүчнээ дотоод эх үүсвэрээс дэвшүүлэн ажиллуулах, сонгон шалгаруулж, мэргэшсэн ажилтан бэлтгэхийг зорьдог

Хүний нөөцийн бүтэц



86

Компанийн
ажиллагсад



32

Эрэгтэй



Дундаж нас

35

9 удаагийн сургалт нийт 40 цаг

Эмэгтэй

54



Ажилласан
дундаж хугацаа

5 жил



Дадлагын оюутан 1



55
Бүрэн дунд




26
Бакалавр



5
Магистр

Санхүүгийн тайлан



**SMART
SALE & DISTRIBUTION**

Борлуулалт түгээлтийн систем



Санхүүгийн тайлан

Санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2022.12.31	2023.06.30
Эргэлтийн харьцаа	4.2	8.9
Түргэн хөрвөх чадварын харьцаа	1.5	3.2
Өр болон өөрийн хөрөнгийн харьцаа	0.7	0.6
Бараа материалын эргэц	1.4	0.7

Санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2022.12.31	2023.06.30
Нийт ашгийн хувь	43.0%	41.4%
Үйл ажиллагааны ашгийн хувь	12.3%	9.5%
Цэвэр ашгийн хувь	11.1%	8.6%
Өөрийн хөрөнгийн өгөөж	16.2%	5.9%



Санхүүгийн тайлан

САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

		мян.төг
Үзүүлэлт	2022.12.31	2023.06.30
Хөрөнгө		
Эргэлтийн хөрөнгө	2,921,556.50	3,166,403.84
Эргэлтийн бус хөрөнгө	1,846,143.40	1,908,362.50
Нийт хөрөнгө	4,767,699.90	5,074,766.34
Өр төлбөр ба эздийн өмч		
Богино хугацаат өр төлбөр	693,471.10	357,146.42
Урт хугацаат өр төлбөр	1,250,000.00	1,525,855.87
Эздийн өмч	2,824,228.80	3,191,764.04
Нийт өр төлбөр ба эздийн өмч	4,767,699.90	5,074,766.34

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

		мян.төг
Үзүүлэлт	2022.12.31	2023.06.30
Энгийн хувьцаа	14,736.70	14,736.70
Дахин үнэлгээний нэмэгдэл	847,420.50	847,420.50
Хуримтлагдсан ашиг	1,962,071.60	2,329,606.82
Нийт эздийн өмчийн дүн	2,824,228.80	3,191,764.02

ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

		мян.төг
Үзүүлэлт	2022.12.31	2023.06.30
Борлуулалтын орлого	4,135,466.70	2,194,658.69
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	2,359,143.40	1,286,294.99
Нийт ашиг	1,776,323.30	908,363.70
Татвар төлөхийн өмнөх ашиг, алдагдал	508,974.10	209,293.78
Орлогын албан татварын зардал	51,924.30	20,938.24
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	457,049.80	188,355.54

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

		мян.төг
Үзүүлэлт	2022.12.31	2023.06.30
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-620,854.70	-46,610.47
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-104,831.40	-9,672.80
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	400,000.00	61,070.70
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-325,697.30	4,524.89
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	660,001.20	334,303.97